



**БУЛГАН АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ**

2024 оны 10 сарын 15 өдөр

Дугаар 1/686.

Булган сум

**Гадаадад албан хэргээр ажиллуулах тухай**

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.9 дэх заалт, Засгийн газрын 2020 оны 190 дүгээр тогтоолоор батлагдсан "Монгол Улсын дипломат, албан гадаад паспорт олгох, эзэмших, хадгалах журам"-ыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Булган аймгийн Засаг даргын Тамгын газрын дарга Д.Алтаншагай, Хутаг-Өндөр сумын Эрүүл мэндийн төвийн дарга Б.Туяацэцэг, Булган сумын Спортын төрөлжсөн сургалттай Ерөнхий боловсролын сургуулийн захирал Л.Наранбат нарыг 2024 оны 11 дүгээр сарын 04-08-ны өдрүүдэд Бүгд Найрамдах Солонгос Улсад албан томиллолтоор ажиллуулсугай.

2.Албан хэргээр ажиллах болсонтой холбогдуулан Гадаад харилцааны яамны Консулын газраас Б.Туяацэцэг, Л.Наранбат нарт гадаад албан паспорт хүссүгэй.

3.Албан хаагчийн гадаад албан паспортын хэрэглээнд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын дарга (Д.Алтаншагай)-д үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА

Б.АРИУН-ЭРДЭНЭ



6324010970